

МОНГОЛ ШҮЛЭГ СУДЛАЛ ДАХЬ ШҮЛЭГЧ, ШҮЛЭГ, УНШИГЧ ГУРВЫН ХОЛБОО ХАМААРАЛ

Г.Галбаяр

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн
Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн профессор

Монгол шүлэг судлалд шийдэх ёстой олон асуудал байгаагийн нэг нь шүлэгч-яруу найрагч, шүлэг-яруу найраг, уншигч-сонсогч гэх үгсийн харьцаа хамаарал, улмаар тэдгээр үгсийн цаанаа илэрхийлэх нэгдсэн ойлголт, утгын асуудал юм. Бидний хувьд монгол шүлэг судлалд шүлэгч-яруу найрагч, шүлэг-яруу найраг, уншигч-сонсогч гэх үгсийн холбоо хамаарал, илэрхийлэх утгыг хоорондын харилцан хамаарал, багтах багталцах харилцаанд нь авч үзээд шүлэг, шүлэгч, уншигч гэх үгс нь уран зохиолын үндсэн гурван төрлийн нэг болох шүлэглэсэн зохиолын үндсэн язгуур утга, мөн чанарыг илэрхийлж байна гэж үзээд эдгээр үгсийн холбоо хамаарлыг тусгайлан авч үзвэл монгол шүлэг судлалын зарим суурь асуудлууд тодорхой болох боломжтой гэж үзсэн билээ. Хүн төрөлхтний уран сайхны сэтгэлгээний онолын суурь тулгуур ойлголт, уугуул мөн чанарыг уран зохиолын үндсэн гурван төрлөөс шүлэглэсэн зохиол түлхүү, тодорхой хадгалдаг байна. Энэ утгаараа шүлэглэсэн зохиолын онолын сэтгэлгээ, туурвин бүтээх дүрслэлийн тогтолцоо ихээхэн ач холбогдолтой.

Шүлэгч; Хувь уран бүтээлчийн авьяас билиг, урлан бүтээх мөн чанарыг чухалчлан үзэж байсан үед (Эртний Грек, Ром, Энэтхэг зэрэг) шүлэгч гэж хэн бэ? шүлэгч хэрхэн төрдөг? шүлэгч юуны учир шүлэг бичдэг? зэрэг олон асуудлуудыг тухайн шүлэгчийн заяамал шинжтэй холбон авч үзэж ирсэн бол нийгмийн сэтгэлгээ хүчтэй болж, аливаа асуудлуудыг нийгмийн сэтгэлгээний үүднээс авч үздэг асан цагуудад (XVIII-XX зуун /ЗХУ зэрэг улсууд/) хувь шүлэгчийг нийгмийн сэтгэлгээ, цаг үетэй хүчтэй холбон авч үзэж ирсэн түүхтэй. Хувь бодгалын шинжийг нь ч, нөгөө талаар нийгэмшсэн шинжийг нь ч чухалчилсан байлаа ч гэсэн ямар ч байсан шүлэг бичдэг шүлэгчийг эгэл жирийн хүнээс эрс өөр нэгэн гэдгийг хүлээн зөвшөөрч байсан нь шүлэгчийн уугуул мөн чанар, авьяас билгийн асуудлыг тусгайлан авч үзэх ёстой гэдгийг харуулж байна. Тийм учраас монгол шүлэг судлалд шүлэгч гэж хэн бэ? гэдэг асуудлаар нэгдсэн зөв ойлголттой болох нь зөв юм.

Шүлэг; Жирийн бус авьяас билиг төгөлдөр нэгэн буюу шүлэгчийн туурвисан шүлэг гэж юу болох? шүлэг ямар үндсэн шинжүүдийг хадгалдаг? Шүлэг ямар бүтэц тогтолцоотой вэ? улмаар шүлгийн бүтэц тогтолцоо тухайн шүлэгчийг төрүүлсэн үндэстний нийтлэг сэтгэлгээтэй хэрхэн холбоотой? зэргийг судлан шинжлүүштэй асуудал болно. Монгол шүлгийг энэ өнцгөөс нь судлавал монгол шүлгийн ерөнхий тогтолцоо тодорхой болох төдийгүй монголчуудын уран сайхны сэтгэлгээний онцлог ч зарим талаар зөв ойлгогдоно.

Уншигч; Авьяас билиг төгөлдөр шүлэгчийн туурвисан нарийн бүтэц тогтолцоо, утга агуулга хосолсон шүлгийг уншигч хэрхэн зөв унших вэ? уншаад тэндээс юу олж мэдрэх вэ? зэрэг зүйл бол шүлэг судлалын чухал асуудлуудын нэг аж. Шүлэг уншигчид хэрхэн нөлөөлөх нөлөө, хамаарлыг дэлгэрэнгүй авч үзэх нь монгол шүлэг судлалын нэгэн чухал асуудал юм.

Шүлгийн онолын сэтгэлгээ хүчтэй хөгжсөн гадны зарим орны шүлэг судлалд шүлэгч, шүлэг, уншигч гурвын холбоо хамаарлыг хэрхэн авч үзэж байгааг монгол шүлгийн судлалд идээшүүлэн, монгол сэтгэлгээ, ахуй, соёл, зан заншлын үүднээс асуудлыг цогцоор нь авч үзэж, нэгдсэн нэг ойлголт бий болгохыг энэ илтгэлд зорьж байгаа болно.